



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026 оны 02 дүгээр сарын 25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: М.Алтантуяа

Утас: 70442424

Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор:

Б.Нарангэрэл

Утас: 99009293

Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан:procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/39
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 94,476.7 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон ерөнхий материаллаг дүнгээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрэй санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Үүнд:

• Тайлант хугацааны сэлбэг хэрэгслийн зардлаас 5,724.5 мянган төгрөг урсгал зардлаас 78,577.7 мянган төгрөгийн аж ахуйн материал нийлүүлэх, засвар хийх нийт 6 гэрээ хийсэн боловч дүгнээгүй, хүлээн авсан актгүй, байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй, зарим гэрээнд ямар материалыг хэдэн ширхэг авах нь тодорхойгүй, өмнөх аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргасан;

6426050120

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-
албан тоот.docx

- Байгууллагын батлагдсан төсөвт гадаад сургалт төлөвлөөгүй байхад бараа үйлчилгээний бусад зардлаас байгууллагын дарга 8,709.5 мянган төгрөгийг зарцуулан гадаад улсад сургалтад хамрагдсан байна;

- Байгууллагын багш, ажилтан, албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, үнэлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулж ажилласан ажлын хэсэгт нийт 1,465.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна.

- Байгууллагын ажилчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолд заасан шалгуур үзүүлэлтийг баримтлалгүй олгосон байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.6 “Хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 “Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэсэн заалт, мөн УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС-12 Бараа материал, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд улсын төсвөөс 4,433,542.7 мянга, орон нутгийн төсвөөс 471,376.4 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 107,789.2 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,433,542.7 мянга, орон нутгийн төсвөөс 471,218.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус сургуулийн хичээлийн байрны хүрэлцээгүйгээс шалтгаалан Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын байранд 3 анги хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн дотуур байрны барилгыг барьж байгаа бөгөөд 2026 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.0 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		952,918,140.47	1,130,597,038.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		593,428,705.51	759,616,515.75
312	Банканд байгаа бэлэн мөнгө		593,428,705.51	759,616,515.75
3121	Төгрөг		593,428,705.51	759,616,515.75
31211	Төрийн сангийн харилцах		593,428,705.51	759,616,515.75
33	АВЛАГА		9,890,568.68	8,338,906.50
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		9,890,568.68	88,906.50
335	Бусад авлага		-	8,250,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		-	8,250,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ		349,598,866.28	362,641,615.95
351	Түүхий эд материал		245,742,434.77	239,371,395.95
35110	Тусгай зориулалттай материал		245,131,434.77	238,588,445.95
35130	Эм боох материал		611,000.00	782,950.00
354	Хангамжийн материал		103,856,431.51	123,270,220.00
35410	Бичиг хэргийн материал		9,851,930.00	25,340,930.00
35420	Аж ахуйн материал		73,639,668.50	74,348,990.00
35430	Сэлбэг хэрэгсэл		584,000.00	584,000.00
35440	Түлш, шатах тослох материал		100,000.00	-
35450	Барилгын засварын материал		9,306,400.00	7,330,000.00
35460	Хүнсний материал		280,533.01	3,609,500.00
35470	Бусад хангамжийн материал		10,093,900.00	12,056,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,552,361,274.46	2,493,668,726.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		2,552,361,274.46	2,493,668,726.33
392	Биет хөрөнгө		1,700,261,274.46	1,641,568,726.33
39201	Барилга, байгууламж, орон сууц		2,072,620,064.61	1,782,991,248.74
39202	Хуримтлагдсан элэгдэл		(844,332,810.06)	(650,017,082.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		178,364,900.00	178,364,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(167,548,233.33)	(169,748,233.29)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		1,874,657,589.42	1,982,859,589.42
39206	Хуримтлагдсан элэгдэл		(1,579,955,577.14)	(1,657,810,675.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		242,199,080.00	248,269,080.00
39208	Хуримтлагдсан элэгдэл		(180,073,047.76)	(194,789,701.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө		37,717,953.00	53,717,953.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(21,248,140.18)	(24,490,248.52)
39217	Ном		87,859,495.90	92,221,895.90
393	Биет бус хөрөнгө		852,100,000.00	852,100,000.00
39301	Программ хангамж		1,760,735.00	1,760,735.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(1,760,735.00)	(1,760,735.00)
39303	Бусад биет бус хөрөнгө		852,100,000.00	852,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,505,279,414.93	3,624,265,764.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,143,197.00	6,214,321.85
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,143,197.00	6,214,321.85
413	Өглөг		1,143,197.00	6,214,321.85
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		1,143,197.00	120,365.85
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		-	5,793,956.00
4136	Бусад өглөг		-	300,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг		-	300,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,504,136,217.94	3,618,051,442.68
51	Засгийн газрын хувь оролцоо		3,504,136,217.94	3,618,051,442.68


Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,945,234,164.54	1,945,234,164.54
51101	Өмч: - төрийн	1,945,234,164.54	1,945,234,164.54
512	Хуримтлагдсан үр дүн	87,722,341.21	201,637,565.95
51210	Өмнөх үеийн үр дүн	(462,007,670.39)	87,722,341.21
51220	Тайлант үеийн үр дүн	549,730,011.60	113,915,224.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,471,179,712.19	1,471,179,712.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,505,279,414.94	3,624,265,764.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,765,021,750.00	5,060,130,973.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		119,283,000.00	155,070,320.00
120	Нийтлэг татварын бус орлого		119,283,000.00	155,070,320.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		5,400,000.00	32,987,420.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	32,987,420.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		5,400,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		102,898,000.00	114,842,900.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		10,985,000.00	7,240,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,645,738,750.00	4,905,060,653.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		4,099,853,200.00	4,433,542,653.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		4,099,853,200.00	4,433,542,653.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		35,777,150.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35,777,150.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		510,108,400.00	471,518,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		510,108,400.00	471,518,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		4,215,291,738.40	4,946,215,748.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,215,291,738.40	4,946,215,748.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,984,980,751.55	4,795,976,732.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,524,968,966.00	3,174,775,971.72
210101	Үндсэн цалин		1,390,409,419.00	3,174,775,971.72
210102	Нэмэгдэл		879,421,161.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт		108,116,293.00	-
210104	Урамшуулал		147,022,093.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		326,063,150.32	407,854,493.50
210201	Тэтгэврийн даатгал		221,782,713.32	277,312,493.50
210202	Тэтгэмжийн даатгал		26,070,139.00	32,635,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		13,035,011.00	16,317,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал		13,035,011.00	16,317,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал		52,140,276.00	65,270,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		485,768,821.71	426,930,548.00
210301	Гэрэл, цахилгаан		19,507,791.71	22,760,000.00
210302	Түлш, халаалт		409,297,759.00	373,479,052.00



Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус		21,963,271.00	30,691,496.00
210304	Байрны түрээс		35,000,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал		80,847,710.00	4,735,300.00
210401	Бичиг хэрэг		27,958,410.00	3,087,000.00
210402	Тээвэр, шатахуун		9,250,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		43,639,300.00	1,648,300.00
2105	Нормативт зардал		59,403,268.93	76,131,293.58
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		611,100.00	-
210502	Хоол, хүнс		57,278,568.93	69,759,993.58
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,513,600.00	6,371,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		32,699,180.00	114,786,078.50
210601	Багаж, техник, хэрэгсэл		-	14,958,963.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		12,319,000.00	43,997,710.00
210604	Урсгал засвар		20,380,180.00	55,829,405.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		-	75,513,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		-	75,513,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		475,229,654.60	515,250,046.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		59,547,237.00	90,568,830.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		213,706,062.83	231,354,268.82
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		201,976,354.77	193,326,948.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		230,310,986.85	150,239,016.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		225,617,088.56	150,097,408.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		80,164,738.56	73,877,408.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		141,958,000.00	76,220,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,494,350.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,693,898.29	141,608.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,693,898.29	141,608.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		549,730,011.60	113,915,224.75
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		549,730,011.60	113,915,224.75

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		4,645,738,750.00	4,938,048,073.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		-	32,987,420.00
120	Нийтлэг татварын бус орлого		-	32,987,420.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		-	32,987,420.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	32,987,420.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,645,738,750.00	4,905,060,653.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		4,099,853,200.00	4,433,542,653.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		4,099,853,200.00	4,433,542,653.00

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		35,777,150.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		35,777,150.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		510,108,400.00	471,518,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		510,108,400.00	471,518,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		4,008,710,244.49	4,752,068,762.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,008,710,244.49	4,752,068,762.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,778,393,607.64	4,601,829,746.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,538,503,933.00	3,165,908,234.19
210101	Үндсэн цалин		1,403,944,386.00	1,585,957,824.28
210102	Нэмэгдэл		879,421,161.00	1,297,004,237.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		108,116,293.00	106,322,677.91
210104	Урамшуулал		147,022,093.00	176,623,495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		326,309,279.00	407,943,400.00
210201	Тэтгэврийн даатгал		222,028,842.00	277,401,400.00
210202	Тэтгэмжийн даатгал		26,070,139.00	32,635,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		13,035,011.00	16,317,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал		13,035,011.00	16,317,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал		52,140,276.00	65,270,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		485,768,821.71	421,376,592.00
210301	Гэрэл, цахилгаан		19,507,791.71	23,000,000.00
210302	Түлш, халаалт		409,297,759.00	373,479,052.00
210303	Цэвэр, бохир ус		21,963,271.00	24,897,540.00
210304	Байрны түрээс		35,000,000.00	-
2105	Нормативт зардал		57,559,101.93	69,479,460.57
210502	Хоол, хүнс		57,559,101.93	69,479,460.57
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		52,257,680.00	77,485,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		32,612,000.00	27,485,300.00
210604	Урсгал засвар		19,645,680.00	49,999,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		-	104,557,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		-	104,557,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		317,994,792.00	355,079,260.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		127,234,297.00	129,578,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		190,760,495.00	225,500,780.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		230,316,636.85	150,239,016.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		225,622,738.56	150,097,408.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		80,164,738.56	73,877,408.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		141,958,000.00	76,220,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		3,500,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		4,693,898.29	141,608.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		4,693,898.29	141,608.00

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		637,028,505.51	185,979,310.24
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		43,599,800.00	19,791,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		43,599,800.00	19,791,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр		43,599,800.00	19,791,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		43,599,800.00	19,791,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(43,599,800.00)	(19,791,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		593,428,705.51	166,187,810.24
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	593,428,705.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		593,428,705.51	759,616,515.75

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	-462,347,478.39	2,954,066,398.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			339,808.00	339,808.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	-462,007,670.39	2,954,406,206.34
C07	Тайлант үеийн үр дүн			549,730,011.60	549,730,011.60
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	87,722,341.21	3,504,136,217.94
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	87,722,341.21	3,504,136,217.94
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	87,722,341.21	3,504,136,217.94
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	113,915,224.75	113,915,224.75
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	201,637,565.96	3,618,051,442.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,012,849,853.00	4,938,048,073.00	74,801,780.00	98.51
Татварын бус орлого	5,012,849,853.00	4,938,048,073.00	74,801,780.00	98.51
Тусламжийн орлого	5,012,849,853.00	4,938,048,073.00	74,801,780.00	98.51
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,433,542,653.00	4,433,542,653.00	-	100.00
Улсын төсвөөс санхүүжих	4,433,542,653.00	4,433,542,653.00	-	100.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	471,518,000.00	471,518,000.00	-	100.00
Орон нутгийн төсвөөс	471,518,000.00	471,518,000.00	-	100.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	107,789,200.00	32,987,420.00	74,801,780.00	30.60
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,041,400.00	32,987,420.00	946,020.00	102.95
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	75,747,800.00		75,747,800.00	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,012,849,900.00	4,771,718,654.76	241,131,245.24	95.2
УРСГАЛ ЗАРДАЛ	5,012,849,900.00	4,771,718,654.76	241,131,245.24	95.2

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,861,914,300.00	4,621,621,246.76	240,293,053.24	95.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,263,545,400.00	3,165,908,234.19	97,637,165.81	97.0
Үндсэн цалин	1,663,072,400.00	1,585,957,824.28	77,114,575.72	95.4
Нэмэгдэл	1,493,225,200.00	1,297,004,237.00	196,220,963.00	86.9
Унаа хоолны хөнгөлөлт	107,247,800.00	106,322,677.91	925,122.09	99.1
Урамшуулал	-	176,623,495.00	176,623,495.00	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	413,307,400.00	407,943,400.00	5,364,000.00	98.7
Тэтгэврийн даатгал	281,048,900.00	277,401,400.00	3,647,500.00	98.7
Тэтгэмжийн даатгал	33,064,600.00	32,635,500.00	429,100.00	98.7
ҮОМШӨ-ний даатгал	16,532,400.00	16,317,800.00	214,600.00	98.7
Ажилгүйдлийн даатгал	16,532,400.00	16,317,800.00	214,600.00	98.7
Эрүүл мэндийн даатгал	66,129,100.00	65,270,900.00	858,200.00	98.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	421,518,000.00	421,376,592.00	141,408.00	100.0
Гэрэл, цахилгаан	23,000,000.00	23,000,000.00	-	100.0
Түлш, халаалт	374,518,000.00	373,479,052.00	1,038,948.00	99.7
Цэвэр, бохир ус	24,000,000.00	24,897,540.00	897,540.00	103.7
Нормативт зардал	119,571,800.00	69,479,460.57	50,092,339.43	58.1
Хоол, хүнс	119,571,800.00	69,479,460.57	50,092,339.43	58.1
Эд хогшил, урсгал засварын зардал	77,646,700.00	77,485,100.00	161,600.00	99.8
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	27,646,700.00	27,485,300.00	161,400.00	99.4
Урсгал засвар	50,000,000.00	49,999,800.00	200.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,557,700.00	104,557,700.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,557,700.00	104,557,700.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	461,767,300.00	374,870,760.00	86,896,540.00	81.2
Бараа үйлчилгээний бусад зардал	195,039,400.00	149,369,980.00	45,669,420.00	76.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	266,727,900.00	225,500,780.00	41,227,120.00	84.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,935,600.00	150,097,408.00	838,192.00	99.4
Бусад урсгал шилжүүлэг	150,935,600.00	150,097,408.00	838,192.00	99.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	74,715,600.00	73,877,408.00	838,192.00	98.9
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	76,220,000.00	76,220,000.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	593428705.51	593,428,705.51	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	759616515.75	759,616,515.75	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	110	107	3	97.3
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	87	84	3	96.6
Үйлчлэх ажилтан	21	21	-	100.0
Гэрээт ажилтан	1	1	-	100.0
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	1	1	-	100.0
Төрийн өмчит МСҮТ	1	1	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1	1	-	100.0

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	110	107	3	97.3
Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	2	2	-	100.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	70	70	-	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1	-	100.0
Гэрээт ажилтан	36	33	3	91.7

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймаг дахь Политехник коллеж нь “Судалгаа шинжилгээ, инноваци, мэдээллийн технологид суурилсан сургалтын чанар, хүртээмж, үр дүнд дээшлүүлэх” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Боловсролын ерөнхий газрын дотоод аудитаас тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь Политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймаг дахь Политехник коллеж нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймаг дахь Политехник коллеж нь 2025 оны санхүүгийн тайлант Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 118,986.3 мянган төгрөг буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	952,918.1	27.2%	1,130,597.0	31.2%	177,678.9	18.6%
Мөнгөн хөрөнгө	593,428.7	16.9%	759,616.5	21.0%	166,187.8	28.0%
Авлага	9,890.6	0.3%	8,338.9	0.2%	(1,551.7)	-15.7%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	349,598.9	10.0%	362,641.6	10.0%	13,042.7	3.7%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,552,361.3	72.8%	2,493,668.7	68.8%	(58,692.5)	-2.3%
Үндсэн хөрөнгө	5,347,279.8	152.5%	5,192,285.4	143.3%	(154,994.4)	-2.9%
Хуримтлагдсан элэгдэл	(2,794,918.5)	-79.7%	(2,698,616.7)	-74.5%	96,301.9	-3.4%
Нийт хөрөнгө	3,505,279.4	100.0%	3,624,265.8	100.0%	118,986.3	3.4%
Өр төлбөр	1,143.2	0.0%	6,214.3	0.2%	5,071.1	443.6%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,504,136.2	100.0%	3,618,051.4	99.8%	113,915.2	3.3%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,505,279.4	100.0%	3,624,265.8	100.0%	118,986.3	3.4%

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 759,616.5 мянган төгрөг байгаа нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 8,338.9 мянга буюу 1,551.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны татвар, нийгмийн даатгалд илүү төлсөн шимтгэлийг тайлант онд суутган тооцсон бөгөөд 2025 оны хичээлийн жилд жолооны сургалтын үйл ажиллагааг шинээр эхлүүлсэнтэй холбогдуулан 8,250.0 мянган төгрөгийн авлагыг тайлагнасанатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 362,641.6 мянган төгрөг болж 13,042.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 509,347.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, 3,420.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 2,260.0 мянган төгрөгийн барилгын засварын материал, 1,560.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд нийт 503,544.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь бараа материалын данс өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,192,285.4 мянган төгрөг болж 154,994.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 19,791.5 мянга, иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 104,510.9 мянган төгрөгийн өртөг бүхий тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар 10,332.0 мянган төгрөгийн өртөг бүхий компьютерийг хүлээн авсан бөгөөд тус байгууллагын барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй 289,628.8 мянган төгрөгийн балансын үнэтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 250 хүүхдийн

хичээлийн байрыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 597 дугаар тогтоолоор акталж данснаас хасах шийдвэр гарсны дагуу данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,214.3 мянга болж 5,071.1 мянган төгрөгөөр өссөн нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 53 дугаар тогтоолоор Баянхонгор-Чандмань ХХК нь цэвэр, бохир усны үнэ тарифаа нэмсэнтэй холбоотойгоор 5,794.4 мянган төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,618,051.4 мянган төгрөг болж 113,915.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 113,915.2 мянган төгрөгтэй холбоотой байна.

Тайлант онд тус байгууллага нь 770.0 мянган төгрөгийн өртөг бүхий Explorer санхүүгийн программ, Волвес ХХК-ны 990.7 мянган төгрөгийн өртөг бүхий номын сангийн программыг сургалтын үйл ажиллагаандаа тус тус ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,346,252.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,346,252.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 333,402.5 мянган төгрөгөөр бууруулж 5,012,849.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 4,433,542.7 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 32,041.4 мянга, өмнө оны үлдэгдлээс 75,747.8 мянган төгрөгийн төсөв баталсан бөгөөд гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,433,542.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 32,987.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,300,342.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,300,342.3 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 97,637.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 5,364.0 мянга, нормативд зардал 50,092.3 мянга, урсгал засвар эд хогшлын зардал 161.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 86,896.5 мянга, Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 838.2 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ төгрөг /

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт %
1	71804 Мэргэжлийн боловсрол	4,541,331,853.00	4,300,342,262.76	233,014,160.24	95.2
1	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	150,935,553.00	150,097,408.00	838,145.00	99.4
2	81806 Дотуур байрны үйлчилгээ	119,571,800.00	69,479,460.57	50,092,339.43	58.1
3	81834 Боловсролын стандарт, сургалты	3,863,594,600.00	3,710,755,084.19	152,839,515.81	96
4	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	373,765,800.00	344,521,640.00	29,244,160.00	92.2
5	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	33,464,100.00	25,488,670.00	7,975,430.00	76.2

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Тайлант онд орон нутгийн төсвөөс 471,518.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 471,518.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 421,376.4 мянган төгрөг, урсгал засварын зардалд 49,999.9 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 141.6 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв.

Бүтэц орон тоог Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар нийт 95 албан хаагчийн орон тоог баталсан бөгөөд Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор бүтэц орон тооны дээд хязгаарыг 110 байхаар тогтоон гүйцэтгэлээр 107 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд цалингийн нийт зардал 3,263,545.4 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 3,165,908.2 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Тус байгууллагын төсөвт хоолны зардлыг 107,247.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 106,322.6 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд Засгийн газрын Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.4 дэх заалтыг үндэслэн өдрийн 3.5 мянган төгрөгөөр тооцон олгосон байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд тус байгууллагад төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 472,049.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төрлийн бараа, ажил үйлчилгээний тендерийг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Тус байгууллага нь 206,023.5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал нийлүүлэх тендерийг 11 багцад, 136,136.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх тендерийг 4 багцад нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 129,890.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 бараа, ажил, үйлчилгээг харьцуулалтын аргаар зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан нийт 58,902.6 мянган төгрөгийн тендерийн хэмнэлтийг бий болгосон байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Дд	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр	Төрөл	Төсөвт өртөг	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, арга	Шалгарсан ААНБ	Гэрээний үнэ
1	Хичээл сургалтын хэрэглэгдэхүүн	Бараа	35,934.0	Харьцуулалтын арга	Бандо электроникс ХХК	28,000.0
2	Хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал	Бараа	206,023.5	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	Препер кран ХХК,	99,587.8
					Ээлгранд ХХК	70,822.1
					Цастын салхи ХХК	15,354.3
3	Сурагчдын хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл	Бараа	23,956.0	Харьцуулалтын арга	Препер кран ХХК,	20,991.4
4	Цэвэрлэгээний материал	Бараа	30,000.0	Харьцуулалтын арга	Фленти трейд ХХК	21,130.0
5	Урсгал засварын материал	Бараа	40,000.0	Харьцуулалтын арга	Эрхэм агужам ХХК	34,739.8
6	Дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материал	Бараа	136,136.0	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	Софт вишн ХХК	72,000.0
					Номгоны андууд ХХК	50,521.5
Дүн			472,049.5			413,146.9

Эх сурвалж: Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 27-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Т.Бат-Ирээдүй, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Баатархуяг нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан нийт төсөвт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.5 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөвт зардал 4,937,103.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 74,056.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 51,839.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 141.4 мянга төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 20,341.5 мянган төгрөгийн 3 гүйлгээ, хуулийн 6.1.1-т заасан байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, тендерт шалгарсан, шалгараагүй оролцогчийн мэдээлэл зэргийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.3, 6.4.5-д заасан мэдээллийг нөхөн байршуулж, цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, аудитаар илэрсэн зөрчилд 1539.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 333.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 13,065.0 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2025.05.30-ний өдрийн 168 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	1539.6	2	1539.6	2
Албан шаардлага	1	333.0	1	333.0	1
Зөвлөмж	1	13065.0	1	13065.0	1
Нийт дүн	1	14,937.5	1	14,937.5	1

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 104,519.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс хандиваар хүлээн авсан 104,510.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан гэсэн ангиллаар бүртгэсэн байгаа нь УСНББОУС-1 Толилуулга ба тодруулга, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, мөн ангилал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 669,633.4 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрснээс 1,805.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 645,379.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 22,449.2 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 103,186.4 мянган төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын багш, ажилтан, албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, үнэлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулж ажилласан ажлын хэсэгт нийт 1,465.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”; Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4 “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, тогтоомжийг зөрчиж илүү олгосон нэмэгдэл хөлсийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.1.2 Байгууллагын дарга нь 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/98 дугаар тушаалаар өөртөө шийдвэр гарган 340.0 мянган төгрөгийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль зөрчиж гаргасан шийдвэрийн дагуу олгосон 340.0 мянган төгрөгийг төсвийн захирагчаар буцаан төлүүлэх төлбөрийн актыг тогтоож, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тайлант хугацааны сэлбэг хэрэгслийн зардлаас зарцуулсан 5,724.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, мөн урсгал зардлаас зарцуулсан 78,577.7 мянган төгрөгийн аж ахуйн материал нийлүүлэх болон засварын 6 гэрээг дүгнээгүй, хүлээн авсан акт үйлдээгүй, байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй, зарим гэрээнд ямар материалыг хэдэн ширхэг авах нь тодорхойгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 “Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх”, 67 дугаар зүйлийн 67.2 “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”; Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын

2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.2.2 “Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй”, 5.12-д “Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжид сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжид их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд хийсэн урсгал засвартай холбоотой тооцооллыг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, зөрчлийг арилган, цаашид давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.2 Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 1 ажилтны 132.0 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн, нэг ажилтын 792.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө”, 32 дугаар зүйлийн 32.2.2 “Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын санд илүү, дутуу мэдээлсэн зөрүүг тооцож, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.3 Байгууллагын батлагдсан төсөвт гадаад сургалт төлөвлөөгүй байхад байгууллагын дарга бараа үйлчилгээний бусад зардлаас 8,709.5 мянган төгрөгийг зарцуулан Филиппин улсад сургалтад хамрагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зардлыг төлөвлөөгүй арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоож алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.4 Байгууллагын ажилчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоходоо Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолд заасан шалгуур үзүүлэлтийг баримтлалгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.5 “Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид хууль, тогтоомж зөрчин олгодог байдлыг таслан зогсоож, журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын үзүүлэлтийг үнэлэн үр дүнгийн урамшууллыг олгож алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.2.5 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 20,341.5 мянган төгрөгийн 3 гүйлгээ, хуулийн 6.4.3 –д заасан тендерт шалгарсан, шалгараагүй оролцогчийн 472,049.0 мянган төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй, хуулийн 6.1.1-т заасан байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4.3 “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж зөрчлийг арилган, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас шилжүүлсэн гүйлгээг худалдан авалтын и баримттай тулгахад 22,449.2 мянган төгрөгийн и баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байгаа нь өр төлбөр үүсэн эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан,

мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо, хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид худалдан авалтын и баримтад тавих хяналтыг сайжруулж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруула агүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс хандиваар хүлээн авсан 104,510.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан гэсэн ангиллаар бүртгэсэн	1	104,510.9			1	104,510.9	1	104,510.9		
Дүн	1	104,510.9			1	104,510.9	1	104,510.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын багш, ажилтан, албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, үнэлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулж ажилласан ажлын хэсэгт нийт 1,465.0 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна.	1	1,465.0	1	1,465.0				
Байгууллагын дарга нь 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/98 дугаар тушаалаар өөртөө шийдвэр гарган 340.0 мянган төгрөгийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.	1	340.0	1	340.0				
Тайлант хугацааны сэлбэг хэрэгслийн зардлаас зарцуулсан 5,724.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, мөн урсгал зардлаас зарцуулсан 78,577.7 мянган төгрөгийн аж ахуйн материал нийлүүлэх болон засварын 6 гэрээг дүгнээгүй, хүлээн авсан акт үйлдээгүй, байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй, зарим гэрээнд ямар материалыг хэдэн ширхэг авах нь тодорхойгүй байна.	1	84,302.2			1	84,302.2		
Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 1 ажилтын 132.0 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн, нэг ажилтын 792.0 мянган төгрөгийг НДШ-ийн тайланд илүү мэдээлсэн байна.	1	924.0			1	924.0		
Байгууллагын батлагдсан төсөвт гадаад сургалт төлөвлөөгүй байхад байгууллагын дарга бараа үйлчилгээний бусад зардлаас 8,709.5 мянган төгрөгийг зарцуулан Филиппин улсад сургалтад хамрагдсан байна.	1	8,709.5			1	8,709.5		
Байгууллагын ажилчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолд заасан шалгуур үзүүлэлтийг баримтлалгүй олгосон байна	1	59,053.0			1	59,053.0		
Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас шилжүүлсэн гүйлгээг худалдан авалтын и баримттай тулгахад 22,449.2 мянган төгрөгийн и баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байгаа нь өр төлбөр үүсэн эрсдэлтэй байна.	1	22,449.2					1	22,449.2
Нийт дүн	7	177,242.9	2	1,805.0	4	152,988.7	1	22,449.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 20,341.5 мянган төгрөгийн 3 гүйлгээ, хуулийн 6.4.3 –д заасан тендерт шалгарсан, шалгараагүй оролцогчийн 472,049.0 мянган төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй, хуулийн 6.1.1-т заасан байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	492,390.5	1	492,390.5		
Дүн	1	492,390.5	1	492,390.5		

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 59/АДСГ.0241/БТИА-2026/150/НА - Номгон
СГА-Т43

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны сэлбэг хэрэгслийн зардлаас зарцуулсан 5,724,000 /таван сая долоон зуун хорин дөрвөн мянган/ төгрөгийн сэлбэг хэрэгсэл, мөн урсгал зардлаас зарцуулсан 78,577,700 /Далан найман сая таван зуун далан долоон мянга долоон зуун/ төгрөгийн аж ахуйн материал нийлүүлэх болон засварын 6 гэрээг дүгнээгүй, хүлээн авсан акт үйлдээгүй, байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй, зарим гэрээнд ямар материалыг хэдэн ширхэг авах нь тодорхойгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 “Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх”, 67 дугаар зүйлийн 67.2 “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна”; “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 3.13 дахь “Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм норматив, стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан

6426090190

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд хийсэн урсгал засвартай холбоотой тооцооллыг өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, зөрчлийг арилган, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн захирал Т.Бат-Ирээдүй, нягтлан бодогч Д.Баатархуяг нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

 Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 60/АД560241/БНА-2026/150/НА-
СТА-ТМЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад 1 ажилтны 132,000 /нэг зуун гучин хоёр/ мянган төгрөгийг дутуу мэдээлсэн, нэг ажилтын 792,000 /долоон зуун ерэн хоёр мянган/ төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө”, 32 дугаар зүйлийн 32.2.2 “Орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан

6426090192

гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нийгмийн даатгалын санд илүү, дутуу мэдээлсэн зөрүүг тооцож, зөрчлийг арилган, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн захирал Т.Бат-Ирээдүй, нягтлан бодогч Д.Баатархуяг нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР:

Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 63/АД560241/БМА-2026/150/НА-СТН Номгон
ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 20,341,500 /хорин сая гурван зуун дөчин нэгэн мянга таван зуун/ төгрөгийн 3 гүйлгээ, хуулийн 6.4.3 –д заасан тендерт шалгарсан, шалгараагүй оролцогчийн 472,049,000 /Дөрвөн зуун далан хоёр сая дөчин есөн мянган/ төгрөгийн 6 мэдээллийг мэдээлээгүй, хуулийн 6.1.1-т заасан байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” , 6.4.3 “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан

“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж зөрчлийг арилган, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн захирал Т.Бат-Ирээдүй, нягтлан бодогч Д.Баатархуяг нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР:

Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 62/АД560241/БМА-2026/150/НА-
СТА-ТМЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын ажилчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолд заасан шалгуур үзүүлэлтийг баримтлалгүй 59,053,000 /тавин есөн сая тавин гурван мянган/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.5 "Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид хууль, тогтоомж зөрчин олгодог байдлыг таслан зогсоож, журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын үзүүлэлтийг үнэлэн үр дүнгийн

6426090198

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

урамшууллыг олгож байх, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн захирал Т.Бат-Ирээдүй, нягтлан бодогч Д.Баатархуяг нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР:

Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 61/А056 2024/1/5117-2026/150/11А-
САА-ТМЗ Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын батлагдсан төсөвт гадаад сургалт төлөвлөөгүй байхад байгууллагын дарга бараа үйлчилгээний бусад зардлаас 8,709,500 /найман сая долоон зуун есөн мянга таван зуун/ төгрөгийг зарцуулан Филиппин улсад сургалтад хамрагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид зардлыг төлөвлөөгүй арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсоож, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 10 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹.

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

6426090196

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн захирал Т.Бат-Ирээдүй, нягтлан бодогч Д.Баатархуяг нарт даалгав².

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР:

Б.НАРАНГЭРЭЛ



² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 17/A0560241/БИА-2026/150/НА-УА Номгон
ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын багш, ажилтан, албан хаагчийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх, үнэлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулж ажилласан ажлын хэсэгт нийт 1,465,000 /нэг сая дөрвөн зуун жаран таван мянган/ төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4 "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачилгаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Холбогдох хууль, тогтоомжийг зөрчиж илүү олгосон 1,465,000 /нэг сая дөрвөн зуун жаран таван мянган/ илүү цагийн нэмэгдэл хөлсийг холбогдох албан тушаалтнуудаар буцаан төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх¹.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 05 дугаар сарын 10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн захирал Т.Бат-Ирээдүй, нягтлан бодогч Д.Баатархуяг нарт хариуцуулав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 18/АДСБ 0241/БТ/А-2026/150/НА-ГА Номгон
ТЧЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын дарга нь 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/98 дугаар тушаалаар өөртөө шийдвэр гарган 340,000 /Гурван зуун дөчин мянган / төгрөгийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль зөрчиж шийдвэр гаргасны дагуу олгосон 340,000 /гурван зуун дөчин мянган/ төгрөгийг төсвийн захирагчаар буцаан төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх¹.


2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2026 оны 05 дугаар сарын 10-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн захирал Т.Бат-Ирээдүй, нягтлан бодогч Д.Баатархуяг нарт хариуцуулав².

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Б.МӨНХБАТ**

АХЛАХ АУДИТОР

Б.НАРАНГЭРЭЛ



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно